



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 05 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 1470

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Н.АМАРЗАЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0006095

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.АМАРЗАЯАГААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

**Асуулга 1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн зарим үйл ажиллагааны талаар:**

**1.1.Иргэдэд 1072 хувьцааны ногдол ашиг тараах талаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга зэрэг олон хүмүүс удаа дараа мэдэгдэл хийсэн. Хэрэв ноогдол ашиг тараахаар ашигтай ажиллаж байгаа бол заавал санхүүжилт босгож, IPO гаргах шаардлагатай эсэх. Компанийн тухай хуульд заасны дагуу энэ шийдвэрийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргах ёстой. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг тараах ямар шийдвэр гарсан талаар:**

Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн хорооны 2010 оны 425 дугаар тогтоол, “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2010 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг байгуулсан бөгөөд тус компани нь өнөөдөр төрийн өмч давамгайлсан хаалттай хувьцаат компани хэлбэрээр холбогдох байгууллагад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК байгуулагдсанаас хойш 2019 оны эхний улирлын байдлаар нийт 207.8 сая м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 50.3 сая тонн нүүрс олборлож, 47.9 сая тонн нүүрс борлуулж, экспортолсон үзүүлэлттэй ажиллаж байгаа бөгөөд үүнээс зөвхөн 2018 онд нийт 11.0 сая тонн нүүрс олборлож, 13.1 сая тонн нүүрс борлуулж, экспортолсон үзүүлэлттэй гарч улсад тэргүүлэх компани болсон байна. Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээр 2018 оны борлуулалтын орлогын хэмжээ 1,986.9 тэрбум төгрөгт хүрч, улсын төсөвт татвар, төлбөр, хураамж хэлбэрээр нийт 478.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд компанийн цэвэр ашиг 807.6 тэрбум төгрөгт хүрч хуримтлагдсан ашиг 807.8 тэрбум төгрөг болсон байна.

Компани хуримтлагдсан ашгаасаа ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэдэг. Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын хүрээнд Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн хөрөнгө босгож, бүтээн байгуулалтыг эхлүүлэх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны 30 хүртэлх хувийг дотоод, гадаадын хөрөнгийн биржид арилжаалах шийдвэрийг гаргасан. Энэ ч агуулгаар компани бүтээн байгуулалтыг эхлүүлэх үндсэн зорилгын хүрээнд, мөн олон нийтээс ирүүлсэн саналын дагуу эхний ээлжинд ногдол ашиг тараахаас илүү зорилтот хүрээндээ бүтээн байгуулалтад зарцуулах нь зүйтэй гэж үзсэн тул төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн. Компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн биржэд арилжаалах асуудал нь нэг талаас Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, нөгөө талаас компанийн хийх дараа дараагийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох зорилготой юм.

**1.2.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах нь олон улсын хөрөнгийн зах зээлд IPO гаргахад сөргөөр**

**нөлөөлөх эсэх талаар:**

Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 41 дүгээр тэмдэглэл болон бусад эрх барих дээд байгууллагын шийдвэрээр Тавантолгойн нүүрсний орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох, үнэт цаасны зах зээлээс тодорхой хэмжээний хөрөнгө татан төвлөрүүлснээр цогц төслүүдийг хэрэгжүүлэх зорилтыг тус компани өмнөө тавиад ажиллаж байна.

Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлж, эдийн засгийн төслүүдийг хэрэгжүүлэхээс өмнө хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилж, төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтад зарцуулдаг олон улсын жишиг байдаг.

Гэвч үнэт цаас гаргаж хөрөнгө босгохоос өмнө томоохон бүтээн байгуулалтын төслийн ажлуудыг эхлүүлж эрчимжүүлэх нь нэн тэргүүний зорилт болж, үнэ цэнийг өсгөхөд чухал ач холбогдолтой юм.

**1.3. Дэлхийн зах зээлд нүүрсний үнэ өндөр байгаа энэ үед “Эрдэнэс-Тавантолгой” ХК нүүрсээ дэлхийн зах зээлийн үнээр худалдан борлуулж байгаа эсэх талаар. Нэг тонн нүүрсийг хэдэн ам.доллараар борлуулж, цаашдын чиг хандлага ямар түвшинд байгаа талаар:**

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн борлуулалт, маркетингийн бодлогоо тодорхойлж ирсэн. 2016 оны сүүлээс эхэлсэн нүүрсний зах зээлийн сэргэлтээс шалтгаалж маркетингийн “Давших” болон “Хамгаалах” стратегиудыг амжилттай хослуулан ажиллаж байна. Компанийн хувьд нүүрсний зах зээлийн төлөв байдал, цаашдын чиг хандлага зэрэг хүчин зүйлсүүдэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр борлуулалтын боломжит доод үнийг тодорхойлдог ба уг үнийг үндэслэн нүүрс худалдан авах сонирхолтой компаниудын дунд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, хамгийн өндөр үнэ ирүүлсэн худалдан авагч компаниудтай гэрээ байгуулдаг, бөгөөд уг үнэ нь дэлхийн зах зээлийн дундаж үнэтэй жишиг байдаг.

**1.4. “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь өөрөө олборлолтоо хийхээр Цанхийн зүүн талбай дахь гэрээт олборлогчтой нүүрс олборлох гэрээг байгуулахгүй шийдвэр гаргасан эсэх талаар. Цанхийн зүүн талбайд гэрээт олборлогчгүй үйл ажиллагаа явуулах нь дэлхийн зах зээлд нүүрсний үнэ өндөр байгаа энэ үед “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 онд олборлох нүүрсний хэмжээг багасгаж төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг бууруулах эрсдэлтэй гэж үзэж байна. Энэ талаар авч байгаа арга хэмжээний талаар:**

Цанхийн зүүн уурхайн үйл ажиллагаа нь гэрээт олборлогчтой байгуулсан гэрээний дагуу хэвийн явагдаж байна. Энэ ажлыг цааш үргэлжлүүлэх асуудал нь төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр хийгдэх шаардлагатай. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор хууль хоорондын зөрчил үүсгэхгүй байх, сонгон шалгаруулалтыг

амжилттай зохион байгуулах зорилгоор тендерийг 2019 оны 6 дугаар сарын 1-ээс эхлэн зохион байгуулахаар компанийн зүгээс бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

**1.5. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг “Эрдэнэс МГЛ” ТӨХХК-ийн охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан:**

Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг охин компани хэлбэрээр биш бие даасан компани болгож өөрчилсөн. Энэ асуудалтай холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн дагуу Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолыг баталж, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн балансыг Эрдэнэс-Монгол ХХК-иас салгаж, бие даасан компани болгосон нь Засгийн газар бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр болно.

**а. Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бус зөвхөн Засгийн газрын 2018 оны 08 сарын 08-ны өдрийн 245 дугаар тогтоолыг үндэслэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК дахь төрийн эзэмшлийн хувьцааг (“Эрдэнэс МГЛ” ХХК-ийн эзэмшиж буй) Уул уурхай, хүнд үйлдвэрийг яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлсэн эсэх талаар:**

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа нь төрийн өмч бөгөөд төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигч нь Засгийн газар болно.

**б. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн бүртгэлтэй хувьцаа эзэмшигч мөн эсэх талаар:**

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигч Засгийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу өөрийн бүрэн эрхийг бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр томилох эрхтэй байдаг. Энэ эрхийн дагуу Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрыг тус тус томилсон.

**в. “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн эзэмшиж буй “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааг хуулийн дагуу шилжээгүй, бүртгэлтэй хувьцаа эзэмшигч биш атлаа хувьцаа эзэмшигчийн бүх эрх, үүргийг Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэх нь томоохон ордын нийгэмчлэл гэж харагдаж болзошгүй гэж үзэж байна. Энэ нь олон улсын хөрөнгийн зах зээлд IPO гаргахад мөн сөргөөр нөлөөлж болзошгүй эсэх талаар:**

Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус компанийн 2018 оны ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж,

компанийн хувьцааны бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг гүйцэтгэх удирдлагад даалгасан.

“Эрдэнэст-Тавантолгой” ХК-ийн хувьцааг үнэт цаасны хадгаламжийн төвд бүртгүүлж, үнэт цаасны хадгаламжийн гэрээг байгуулах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр аваад байна. Түүнчлэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон талаарх өөрчлөлтийг 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр бүртгүүлж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай хувьцааг хадгаламжид бүртгэх, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээг 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан байна.

**Асуулга 2. Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын 1 дэх зүйлийн 1 дэх хэсэгт заасан Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах талаар:**

**2.1.Улсын Их Хурлын тогтоолоор Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах бэлтгэл ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, биелэлтийн талаар 2018 ондоо багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн Газарт даалгасан. Энэ дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээлд IPO гаргах ажлын явцыг Улсын Их Хуралд өнөөдрийг хүртэл танилцуулаагүй байгаад дүгнэлт хийж, юуны улмаас уг тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байгаа талаар:**

Хуулийн этгээдийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгох буюу биржээр дамжуулан үнэт цаас нийтэд санал болгох харилцаа нь тодорхой төлөвлөгөөний үндсэн дээр нарийн зохицуулалттай хууль, дүрмийн дагуу сайтар бэлтгэгддэг, үнэт цаасыг зах зээлд байршуулах, үнэ тогтоох, арилжаалах үе шатуудад үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч этгээдийн үйлчилгээ, оролцоог шаардсан цаг хугацаа, санхүүгийн өндөр зардалтай ажиллагаа юм. Үнэт цаас гаргах бэлтгэл ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан, танилцуулгыг 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

**2.2.Санхүүгийн зохицуулах хороо “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг хаалттай хувьцаат компаниар бүртгэж, хувьцааг хадгаламжид бүртгэн авахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д зөвшөөрсөн байна. Юуны улмаас “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийг нээлттэй бус, хаалттай хувьцаат компаниар бүртгэсэн талаар, Үүнд иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцаа болон зарим аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж буй хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа хэзээ эхлэхээр төлөвлөж байгаа талаар:**

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрэмд хуулийн этгээдийн хэлбэрийг хаалттай хувьцаат компани гэж тусгасан боловч үнэт цаасны хадгаламжийн төвд гаргасан үнэт цаасаа бүртгүүлээгүй, компани 2 сая гаруй хувьцаа эзэмшигчидтэй атлаа хувьцаа эзэмшигчдийн бүртгэлээ хөтөлдөггүй зэрэг нь Компанийн тухай хуулийн 3.8-д “Хаалттай хувьцаат компани гэж ... хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн байгууллагад бүртгэгдэж, ...” гэж, тус хуулийн 45.1-д “Компани нь үнэт цаас

эзэмшигчдийн бүртгэлийг хөтөлж, үнэт цаасыг биет байдлаар гаргасан бол түүнийг хадгалах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.” гэж заасныг тус тус зөрчиж байсан.

Иймд 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хаалттай хувьцаат компанийн бүртгэлийг холбогдох эрх бүхий этгээдэд бүртгүүлэх, гадаад, дотоодын хөрөнгийн биржийн шаардлагад нийцүүлэн хараат, охин компанийг дангаар болон бусадтай хамтран байгуулах зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон түүний нэгдлийн оролцогч компанийн хувьцааг нийтэд санал болгон арилжаалах асуудлуудыг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу бэлтгэн холбогдох эрх бүхий этгээдэд хүргүүлсэн бөгөөд “Эрдэнэст-Тавантолгой” ХК-ийн нэг бүр нь 933 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 12,000,000,000 ширхэг хувьцааг үнэт цаасны хадгаламжийн төвд бүртгүүлж, үнэт цаасны хадгаламжийн гэрээг байгуулах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр авсан.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь дээрх зөвшөөрлийг авах асуудлаар 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороонд хандсан боловч тус Хорооны зүгээс ямар нэгэн хариу өгөхгүй байсаар 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр шийдвэрлэсэн нь үнэт цаасны бүртгэлийг хууль зүйн хувьд баталгаажуулах, бүртгэлийг ямар нэгэн зөрүүгүй тулган тогтоох, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэх ажиллагааг цаг хугацааны хувьд нилээд хойш нь татсан асуудал бий. Тодруулбал, Эрүүгийн цагдаагийн газарт хувьцаа эзэмшигч иргэдийн хувьцааны эзэмшилтэй холбоотой маргаан зөрчил байгаа бөгөөд энэ зөрчлийг даруй арилгах шаардлагатай байна.

Компанийн хувьцааг гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах хугацаатай уялдуулж иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй 1072 ширхэг хувьцааны арилжааг нэг зэрэг, эсхүл дараа нь эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**2.3. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан арилжихаар төлөвлөж байгаа болон бэлтгэл ажлын явцын талаар.** Ялангуяа гадаадын хөрөнгийн биржийн шаардлагад нийцүүлэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн зүгээс үнэлгээ, аудит, хууль зүйн зэрэг бэлтгэл ажлыг хэрхэн хангаж байгаа талаар:

Нийт хувьцааны 30 хүртэлх хувийг гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах асуудлыг Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А-30 дугаар тушаал, 2019 оны 3 дугаар сарын 20-ны А-150 дугаар тушаалаар шаардлагатай бүхий л мэдээлэл, баримт бичгийг бэлтгэж танилцуулах, магадлан шинжилгээний ажилд бэлтгэх, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх болон үнэт цаас гаргах компанийн урьдчилсан үнэлгээг тооцоолох, холбогдох төслүүд болон хувьцаа гаргах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилготой Ажлын хэсгүүдийг тус тус байгуулж, дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

1. Нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, холбогдох магадлан шинжилгээний ажилд бэлтгэх;
2. Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулах, санхүүгийн загварчлал гаргах;
3. Хувьцааг хөрөнгийн биржээр бүртгүүлэхэд шаардагдах ажлуудын бэлтгэлийг хангах;
4. Компанийн үнэлгээг нэмэгдүүлэх дэд бүтцийн төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад бэлтгэх;
5. Хувьцааг гадаадын хөрөнгийн биржид бүртгүүлэхэд шаардлагатай бүтцийн өөрчлөлтийг хийх саналыг боловсруулах;
6. Хувьцааны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид, олон нийтэд хүргэх төлөвлөгөөг боловсруулах;
7. Компанийн дотоод зохион байгуулалтыг олон улсын сайн жишигт нийцүүлэх.

**2.4.IPO гаргах хөрөнгийн биржээр Нью-Йорк эсвэл Хонконгийн биржийг сонгосон талаар компанийн удирдлагын түвшинд олон нийтэд мэдээлсэн. Эдгээр гадаадын хөрөнгийн биржүүдийг ямар шалгуураар сонгосон болон биржийн харьцуулсан судалгаа, мэдээллийг судалсан эсэх болон тухайн сонголтын давуу талыг илэрхийлбэл:**

Хувьцааг арилжаалах гадаадын хөрөнгийн биржийг сонгоход тухайн хөрөнгийн биржийн шалгуур үзүүлэлт, зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хөрөнгө оруулагчдын бааз суурь, тэдгээрийн хувьцаа гаргах этгээдийн бүс нутаг, улс төрийн нөхцөл байдлын талаар мэдлэг зэрэг чухал ач холбогдолтой. Хувьцааг олон нийтэд санал болгох компанийн нөхцөл байдалд илүү тааламжтай, зорилтот хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж чадах хөрөнгийн бирж, зах зээлийг сонгох нь зүйтэй байдаг.

Дээрх ажлын хүрээнд Засгийн газрын 2018 оны 224 дүгээр тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай хамтран Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанд гадаадын хөрөнгийн биржийг сонгох тухай танилцуулга хийсэн. Улмаар уг өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд хувьцааг арилжаалах гадаадын хөрөнгийн биржээр Нью-Йорк болон Хонконгийн хөрөнгийн биржийг сонгох асуудлыг судлан шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасан.

Үүний дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс хөрөнгийн биржийг сонгох судалгааг биржүүдийн хууль зүйн шаардлага, зах зээлийн үнэлгээ, удирдлагуудтай хийсэн уулзалтын үр дүнд боловсруулсан. Уг судалгааг холбогдох шийдвэрийн төслийн хамт компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн Хонконгийн хөрөнгийн биржийг сонгох тухай 02 дугаар тогтоолыг баталсан.

Компанийн зүгээс хөрөнгийн биржийг сонгохдоо хөгжиж байгаа орнууд, тэр дундаа Монголын зах зээлийн талаархи хөрөнгө оруулагчдын мэдлэг, төрийн өмчит болон уул уурхайн салбарын компаниудын хувьцаа гаргаж байсан туршлага, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зах зээлийн үнэлгээ зэрэг үзүүлэлтүүдийг болон манай улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага, арилжаа эрхлэх байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах хууль, эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн зэрэг голлох үзүүлэлтүүдийг анхаарч үзсэн.

Томоохон хөрөнгийн биржүүдийг харьцуулсан товч танилцуулгыг Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Томоохон хөрөнгийн биржүүдийг харьцуулсан байдал

Бирж	Давуу талууд	Сул талууд
Хонконг	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө оруулагчид Монголын талаар мэдлэгтэй,</li> <li>• MMC, Mongolia Energy Corporation, South Gobi Sands зэрэг Монгол компаниуд амжилттай гарч байсан,</li> <li>• Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн арилжаа харьцангуй олон хийгддэг,</li> <li>• Хамгийн хөрвөх чадвартай зах зээлийн нэг бөгөөд Азид хамгийн их хөрөнгө татан төвлөрүүлдэг бирж,</li> <li>• Хууль зүйн зохицуулалт нь арилжааг хурдан явуулахад хамгийн тохиромжтой,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Амралтын өдрийн тоо бусад хөрөнгийн биржээс их (15 хоног),</li> <li>• Зах зээлийн үнэлгээ Нью-Йоркийн биржтэй харьцуулахад бага</li> </ul>
Нью-Йорк	<ul style="list-style-type: none"> <li>• Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар дэлхийд хамгийн өндөр</li> <li>• Хойд Америк, Ази, Европ дахь хөрөнгийг татах боломжтой,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Өргөн хүрээг хамарсан нарийн төвөгтэй зохицуулалттай (SOX г.м)</li> <li>• Өндөр өртөгтэй бэлтгэл ажил, дагаж мөрдөх шаардлагууд ихтэй</li> <li>• Цагийн зөрүүтэй бөгөөд орон зайн хувьд хол, шууд нислэггүй</li> </ul>
Лондон	<ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхайн компаниудын үнэт цаас гарч байсан туршлага ихтэй,</li> <li>• Тодорхой хэмжээнд хөгжиж буй эдийн засагтай орнуудын IPO хийсэн туршлагатай (ОХУ, Казакстан г.м)</li> <li>• Нью-Йоркийн хөрөнгийн биржийн дараа орох хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй бирж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нарийн, цаг хугацаа их орох зохицуулалттай,</li> <li>• Хөгжиж буй зах зээлд гардаг аливаа гэнэтийн шийдвэрт таагүй ханддаг,</li> <li>• Аливаа шаардлага хангаагүй тохиолдолд хүлээх хариуцлага өндөр,</li> <li>• Бэлтгэл ажлын зардал их,</li> <li>• Хөрөнгө оруулагчид Африк болон Зүүн Европ, Төв азийн орнуудын талаар илүү мэдлэгтэй,</li> </ul>
Торонто	<ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхайн компаниудын үнэт цаас гарч байсан туршлага ихтэй,</li> <li>• Монгол Улсад хөрөнгө оруулагчдыг татаж байсан туршлагатай</li> <li>• Хойд Америк дахь хөрөнгийг татах боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсад хөрөнгө оруулах холимог туршлагатай (Хан Ресурс, Сентерра, TRQ-ийн туршлага нь хөрөнгө оруулагчид сөрөг сэтгэлдэл төрүүлсэн байх магадлалтай),</li> <li>• Хөгжсөн зах зээл тул харьцангуй өндөр шаардлага тавьдаг,</li> <li>• Цагийн зөрүүтэй бөгөөд орон зайн хувьд хол, шууд нислэггүй,</li> <li>• Нүүрсний салбарт зах зээлийн үнэлгээ бага ба шинжээчдийн дүгнэлт хангалтгүй.</li> </ul>

Хонконгийн хөрөнгийн бирж (ХКХБ) нь үндсэн болон GEM /Growth enterprises market/ гэсэн 2 самбартай. ХКХБ нь харьцангуй хялбар засаглалын шаардлагатай байдаг, дэлхийн хамгийн том төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг арилжаалах



замаар амжилттай хувьчилсан (China Construction bank SOE болон ICBC SOE) туршлагатай бирж юм.

Мөн Монгол Улстай нэг цагийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг, орон зайн хувьд ойр бөгөөд шууд нислэгтэй зэрэг нь бэлтгэл ажлын хүрээнд болон хувьцаа гаргасны дараа өдөр тутмын арилжаанд тогтмол хяналт тавих, хөрөнгө оруулагчидтай мэдээлэл шуурхай харилцан солилцох, биржийн болон холбогдох зохицуулах хороотой аливаа харилцааг цаг алдалгүй хийж, шаардлага биелүүлж, хамтран ажиллахад нэн тохиромжтой.

Түүнчлэн “Монголиан Майнинг Корпорейшн” компанийн үнэт цаасны арилжаа, түүний дахин санхүүжилтийг амжилттай шийдвэрлэсэн зэрэг нь Монголд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын талаар хөрөнгө оруулагчдын мэдээлэл, боловсрол хамгийн өндөр, амжилттай хөрөнгө оруулсан туршлагатай бирж юм.

**2.5. Сонгогдсон гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааг худалдан авах хөрөнгө оруулагчдын урьдчилсан судалгааг хэрхэн гүйцэтгэж байгаа талаар;**

**2.6. Хэрэв Хонконгийн хөрөнгийн биржээр дамжуулан хувьцааг арилжих тохиолдолд Хонконгийн хөрөнгийн биржтэй Монгол Улсыг тус хөрөнгийн биржид хүлээн зөвшөөрөгдсөн улсад тооцох хөнгөлөлттэй нөхцөлийг тохиролцсон эсэх эсвэл тус биржээс хүлээн зөвшөөрөгдсөн улсад “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хамаарал бүхий этгээдийг байгуулахаар шийдвэрлэсэн эсэх талаар. Мөн бусад хөрөнгийн бүржүүдээс “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д IPO гаргахтай холбоотой хөнгөлөлттэй нөхцөл санал болгосон эсэх талаар;**

**2.7. Хэрэв хувьцааг гадаад улсад бүртгэлтэй “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хамаарал бүхий этгээдээр дамжуулан гадаадын хөрөнгийн бирж дээр арилжих тохиолдолд нийт иргэд, аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж буй хувьцааг олон улсын түвшинд нээлттэй арилжих хоёр дахь зээлийн арилжааг хэрхэн төлөвлөж байгаа талаар. Ялангуяа Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй этгээдийн хувьцааны 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаална гэсэн зохицуулалтыг зөрчиж байгаа эсэхэд хэрхэн тайлбар өгөх талаар;**

**2.8. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан арилжсанаар ямар хэмжээний хөрөнгө мөнгө татан төвлөрүүлэх тооцоолол, үнэт цаасны танилцуулга байгаа эсэх, тооцоолол бодитой эсэх, ямар судалгаанд үндэслэсэн талаар;**

**2.5, 2.6, 2.7, 2.8 дахь асуулгын хариулт:** Үнэт цаасны зах зээлийн харилцааны зохицуулалт нь ямар нэгэн дарамт шахалтгүйгээр, бизнесийн удирдлага, засаглалын болон хууль зүйн нарийн зохицуулалт, оролцогч талуудын чөлөөтэй итгэл үнэмшил, итгэлцэл дээр суурилдаг бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан өөрийн үнэт цаасыг амжилттай арилжаалах нь ямар ч бизнесийн байгууллагын хувьд нэр хүндийн асуудал юм.

Иймд олон улсын хөрөнгийн биржээс оролцогч этгээдийг маш нарийн шалгуурыг хангасан байхыг шаарддаг бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаас шийдвэр гаргуулахтай холбоотойгоор төрийн эрх барих дээд байгууллагаас нөлөөлөл үзүүлэх ямар ч боломжгүй юм.

Иймд үнэт цаас гаргах ажиллагааны нарийвчилсан мэдээллийг тодорхой хэмжээгээр нууцалж байх шаардлагатай байдаг, энэ нь эргээд тухайн IPO гаргах ажиллагааны амжилтад нөлөөлөх хүчин зүйлсийн нэг юм.

Нөгөөтэйгүүр, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй байгаа тохиолдолд зах зээлд өөрчлөлт оруулах аливаа мэдээллийг нийтэд түгээхийг хориглодог бөгөөд тус хуулийн 7 дугаар бүлгийн 76, 77, 78, 79 дүгээр зүйлүүдээр холбогдох харилцааг зохицуулсан болно.

**2.9.Гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан Тавантолгойн ордын хувьцаа эзэмшигч ("Эрдэнэс-Тавантолгой" ХК эсвэл түүний хамаарал бүхий этгээд)- ийн хувьцааг арилжихтай холбоотойгоор сонгогдсон хөрөнгийн биржээс компанийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг барьцаалах эсвэл түүнтэй адилтгах хязгаарлалтыг тогтоох зохицуулалт байгаа эсэх талаар. Өөрөөр хэлбэл, олон улсын хөрөнгийн бирж дээр IPO гаргаснаар стратегийн орд газар болох Тавантолгойн ордын тусгай зөвшөөрлийг алдах эрсдэл байгаа эсэх талаар. Тухайлбал, хувьцааг нийтэд санал болгон арилжсаны дараа гадаадын хөрөнгийн биржийн шаардлагыг хангаж чадахгүй эсвэл хувьцааны үнэ унасан зэргээс үүдэлтэйгээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх эрсдэлтэй байдал үүсэж болох эсэх талаар. Энэ талаар эрсдэлийн дүн шинжилгээ, судалгаа хийсэн талаар:**

Хөрөнгийн биржийн бүртгэлд үнэт цаасыг бүртгүүлснээр тухайн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг барьцаалах асуудал үүсэхгүй. Тухайн үнэт цаас гаргагч нь биржийн шаардлагыг хангаж чадахгүй болох, хувьцааны ханш унах зэрэг аливаа тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй болно. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд барьцаалахыг хориглодог бөгөөд уг заалтад хөрөнгийн биржэд бүртгүүлэх замаар тусгай зөвшөөрлийг барьцаалах эрх олгогдоогүй болно. Хэрэв энэ эрхийг зөрчиж аливаа гэрээ байгуулах бол Иргэний хуулийн 56 дугаар зүйлд зааснаар уг гэрээ нь хүчин төгөлдөр бусад тооцогдох нөхцөлтэй.

Тавантолгойн нүүрсний стратегийн ордыг 51-ээс дээш хувийн эзэмшилтэй Монгол Улсын хуулийн этгээд "Эрдэнэс-тавантолгой" ХК болон түүний нэгдлийн оролцогч охин компани эзэмших болно.

**2.10."Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2019 оны төсөвт багтсан 283 тэрбум төгрөгийн үнэтэй IPO-той холбоотой зөвлөх үйлчилгээний зардлыг ямар тооцоолол, юунд үндэслэж гаргасан талаар:**

Компанийн 2018 оны төсвийг батлахдаа IPO гаргах ажилтай холбоотой зөвлөх үйлчилгээний зардлыг долларын ханшийн зөрүүг тооцон 283,359,500 мянган төгрөг байхаар баталсан. Үүний 258,810,000 мянга нь андеррайтерийн үйлчилгээний төлбөр, үлдсэн нь техникийн зөвлөх, санхүү аудитын зөвлөх, хуулийн зөвлөх болон

бусад хураамж, шимтгэл байсан юм. Гэвч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан дээрх төсөвт тодотгол хийсэн.

**2.11.Тавантолгойн орд газрын доорх баялгийн өөрийн үнэлгээ урьдчилсан байдлаар хэд болох талаар гаргасан судалгаа байгаа эсэх. Тэр дүнгээрээ ямар үнэтэй нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) тооцоолол, үнэлгээ хийсэн талаар:**

АНУ-ын Норвест компани 2012 онд Тавантолгой нүүрсний ордын нөөцийг ЖОРК стандартанд дүйцүүлэн нийт 7.384 тэрбум тн буюу түүнээс 985.5 сая тн нь баттай, 2,986.0 сая тн нь бодитой, үлдсэн 3,410.6 сая тн нь боломжит нөөц гэж тогтоосон. Үүнээс 5.4 тэрбум тн нь коксжих нүүрс бол 1.9 тэрбум тн нь эрчим хүчний нүүрс байна.

Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр 2018 онд "Эрдэнэс Тавантолгой" ХК нь Тавантолгойн ордын нөөцийг блок аргачлалаар нийт 6.3 тэрбум тонноор батлуулсан. Түүнчлэн, компанийн зүгээс IPO-тэй холбогдуулан ордын нөөцийг тогтооход олон улсад баримталдаг ЖОРК стандартын дагуу нөөцийг дахин тогтоолгох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

**Асуулга 3. Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт урьдсан Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх ажлын биелэлтийн талаар:**

**3.1.IPO гаргаснаар татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаар Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хэдэн төгрөгийн өртөгтэй дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх гэж байгаа талаар. Дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийн өнөөгийн түвшинд бэлтгэгдэж байгаа төслийн талаар:**

Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлнэ. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үндсэн үйлдвэрлэл, санхүүгийн үзүүлэлтүүд болон гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах үеийн зах зээлийн нөхцөл байдлаас хамааран 3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх урьдчилсан тооцоололтой байна.

**3.2.IPO гаргаснаар татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг ямар шалгуур, эрэмбээр сонгосон талаар. Эдгээр төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн эсэх, төслүүдийн эдийн засгийн үр өгөөжийн тооцооллын талаар:**

Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжих төмөр зам, авто зам, цахилгаан станц, усан хангамж зэрэг 10 төсөл, Тавантолгойн уурхайн үйл

ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хөрс тээврийн конвейер, нүүрс баяжуулах үйлдвэр, кокс эрчим хүчний 8 төсөл, ирээдүйд Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх нүүрсний давхаргын метан хий төсөл гэсэн Тавантолгой ордтой холбоотой нийт 20 гаруй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр компанийн бизнес төлөвлөгөөнд тусган, эдийн засгийн үр ашиг, цаг хугацаа болон ач холбогдлоор нь үе шаттайгаар хэрэгжүүлэхээр зорьж байна.

Компанийн зүгээс нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай төсөлд төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, авто-конвейерийн систем, нүүрс ачиж буулгах терминал болон усан хангамжийн төсөл багтсан. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Тавантолгойн уурхайн ус хангамжийн системийн ТЭЗҮ боловсруулах, нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах, Цанхийн баруун уурхайн хөрсний тээвэрт конвейерийн систем нэвтрүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулах ажлууд тусгагдан, техник эдийн засгийн үнэлгээг боловсруулахаар холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

**3.3. "Энержи Ресурс" ХХК-ийн толгой компани болох "Mongolian Mining Corporation" групп 2018 жилийн санхүүгийн тайлангаа олон нийтэд танилцуулсан мэдээллээс үзэхэд тус компани 2018 онд 1 тонн баяжуулсан нүүрсийг эцсийн хэрэгчлэгчдэд 170 ам.доллороор борлуулсан байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд "Энержи Ресурс" ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрт "Эрдэнэс-Тавантолгой" ХК нүүрсээ угааснаар компанийн өрсөлдөх чадвар, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг судалсан эсэх талаар:**

Засгийн газраас баримталж байсан нүүрсний экспортын нэг цонхны бодлогын хүрээнд 2013 оны 12 сард "Энержи Ресурс" ХХК-тай туршилтын журмаар 40 мян.тн нүүрс угаалгах гэрээ байгуулж, хамтран ажилласан. "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон Энержи Ресурс ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний тайланд тусгагдснаар "Эрдэнэс-Тавантолгой" ХК-аас дунджаар 10% үнслэгтэй, 80-85% гарцтай баяжмал авахаар төлөвлөсөн ч нүүрс баяжуулах үйлдвэрийн тохируулгаас шалтгаалж 8,5% үнслэгтэй 73%-ийн гарцтай, 30.5 мян.тн баяжмал үйлдвэрлэсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу 2017 оны 5 дугаар сард "Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх" ажлын хэсгийг байгуулж, энэ хүрээнд "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон "Энержи Ресурс" компаниудын төлөөлөлтэй уулзаж хөрш зэргэлдээ компаниуд хамтран ажиллах чиглэл өгсөн. Уг чиглэлийн дагуу "Энержи Ресурс" ХХК "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д өгөх 7.7 сая ам.долларын өглөгийнхөө оронд тохирох хэмжээний нүүрсийг угаах үйлчилгээ үзүүлж хамтын ажиллагааны эхлэлийг тавихаар тохиролцсон.

Компанийн зүгээс 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан дотоодын нүүрс баяжуулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах боломжийг судлах хүрээнд ажлын хэсэг байгуулан холбогдох ажлуудыг хийж байна.

**3.4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг хэвлэл мэдээллийн хэрэгслээр Тавантолгойн ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд IPO гаргаснаар татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалт хүрэлцэхгүй, БНХАУ-ын төрийн өмчит "Чайна Энержи" компанийн хөрөнгө оруулалт зайлшгүй хэрэгтэй, энэ ажлын**

гэрээ хэлэлцээрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар хийж байгаа талаар мэдээлсэн. Энэ мэдээлэл бодитой, үнэн эсэх, үнэн бол БНХАУ-ын төрийн өмчит "Чайна Энержи" компани ямар нөхцөлөөр, ямар хэмжээний хөрөнгө оруулалтыг Тавантолгойн ордод хийх гэж байгаа, ямар шалгуураар тус компанийг сонгон ажиллаж байгаа талаар. Гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагаа ямар түвшинд явагдаж байгаа талаар, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох журмуудад нийцэж байгаа эсэх тухай

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн зүгээс тавантолгойн төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, түүнийг дагалдах дэд бүтцийн хамт хөгжүүлэх асуудлаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээ хийх зорилгоор энэ асуудлаар харилцан мэдээлэл солилцох уулзалтыг хөрөнгө оруулагч нартай хийж ажиллаж байна. Үүний нэг нь БНХАУ-ын төрийн өмчит "Чайна Энержи" компани бөгөөд энэхүү уулзалт нь компанийн түвшинд харилцан санал солилцох хэлбэрээр хийгдсэн болно.

**3.5."Чайна Энержи" компаниас авах хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тохиолдолд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан арилжих шаардлага байхгүй мэт төсөөлөл төрж байна, энэ талаар:**

Улсын Их Хурал 2010 оноос 2018 он хүртэлх хугацаанд нийт 4 тогтоол гаргаж, улс орны хэмжээнд эдийн засгийн чухал ач холбогдолтой Тавантолгойн нүүрсний орд газрын тусгай зөвшөөрлийг эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг дотоод, гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалж, хөрөнгө босгож, шаардлагатай төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж хэрэгжүүлэхээр тус тус шийдвэрлэсэн. Иймээс ч "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьд нэн тэргүүнд IPO-ээс хөрөнгө босгох замаар ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, цаашид Монгол Улс уул уурхай, тэр дундаа тавантолгойн ордоос хүртэх ашгийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах нь Улсын Их Хурлаас баталсан тогтоолыг хэрэгжүүлэх чухал алхам юм.

**3.6."Чайна Энержи" компанийн хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа тохиолдолд IPO гаргахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан зохих заалт нөлөөлж байгаа эсэх талаар:**

Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй гэж заасны дагуу Тавантолгойн ордыг эзэмшигчийн хувьцааг олон улсын хөрөнгийг биржэд арилжаалахад шаардлагатай үйлчилгээг худалдан авахад тендерийн хуулийн нөхцөл шаардлага хамаарахгүй болсон. Өөрөөр хэлбэл, IPO хийхтэй холбоотой худалдан авах зөвлөх үйлчилгээг тендерийн журмаар биш, олон улсын нөхцөл шаардлагад нийцүүлэн худалдан авах боломжтой болж байна. Харин, энэхүү төсөлтэй холбоотойгоор бараа болон ажлыг

худалдан авахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу холбогдох тендерийг зохион байгуулах юм.

Тус компани нь дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай ямар ч компанитай бизнесийн үйл ажиллагааны хүрээнд харилцан үр ашигтайгаар хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр хэлэлцээр хийж болох эрхтэй. Гэвч өнөөдрийн байдлаар "Чайна Энержи" компанитай хамтын ажиллагааны аливаа гэрээ, хэлэлцээр байгуулаагүй болно.

**3.7.Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх арга хэмжээний талаар болон төслүүд ямар эх үүсвэрээр санхүүжиж байгаа талаар. Шинээр үүсгэн байгуулагдсан "Тавантолгой Төмөрзам" ХХК дахь "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хөрөнгө оруулалтын хэмжээ, нөхцөлийн талаар:**

Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тусгагдсан шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх төслүүдийн тоонд Тавантолгой ордтой холбогдох тус хоёр чиглэлийн төмөр замын төсөл багтсаны дагуу Засгийн Газраас 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг, 2019 оны 135 дугаар тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг тус тус санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг холбогдох яамд болон төрийн өмчит компаниудад даалгаснаар төслийг эхлүүлэх бодлогын арга хэмжээ авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар "Тавантолгой- Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай" 242 дугаар тогтоолыг баталсан ба тухайн чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн барилгын ажлыг эхлүүлэх шийдвэр гарсан. Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар "Монголын төмөр зам" ТӨХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-иуд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийг үүсгэн байгуулаад байна.

Мөн Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар тус тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэхийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д даалгасан тухай 08 дугаар тэмдэглэл гарсан.

Тусгай зориулалтын "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэрэгжүүлэх Тавантолгой- Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх ажил хүлээгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн, хүүгүй, 20 хүртэл жилийн хугацаатай 750.0 ( долоон зуун тавин) тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд худалдахаар гаргах зөвшөөрлийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгохыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, "Монголын төмөр зам" ТӨХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Р.Мэргэн)-д тус тус даалгасны дагуу холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна. Төсөлд шаардагдах үлдэгдэл санхүүжилтийг Монгол банкны дэмжилгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж

шийдвэрлэхээр болсон.

Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08 өдрийн 242 дугаар тогтоолын дагуу "Монголын төмөр зам" ТӨХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр "Тавантолгой төмөр зам" ХХК-ийг үүсгэн байгуулсан. "Монголын төмөр зам" ТӨХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу "Эрдэнэс тавантолгой" ХК нь "Тавантолгой төмөр зам" ХХК -д хөрөнгө оруулж хувь эзэмших эрх нь нээлттэй байгаа. Төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төрд ногдохоос бусад хувьд хөрөнгө оруулах этгээдийг урьдчилгаа төлбөр, боомт ашиглапт, дамжуулан тээвэрлэлт хийх боломжтой гадаадын хөрөнгө оруулагч нараас судлан хэлэлцээ хийх зэрэг замаар шийдвэрлэхээр ажиллаж байна.

Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 53 дугаар захирамжаар Монгол Улсын сайд, Монгол Улсын Хэрэг эрхлэх газрын даргын ахалж, холбогдох салбарын сайдууд болон "Улаанбаатар төмөр зам" ХНН, "Монголын төмөр зам" ТӨХК, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдаад байна.

**Асуулга 4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Орон нутгийн хөгжил, говьчуудын төлөө хийгдэж байгаа үйл ажиллагааны талаар**

**4.1. Гашуун сухайт чиглэлийн нүүрсний авто зам дээр сүүлийн жилүүдэд замын даац хэтэрч, эвдэрч сүйдсэний улмаас эрдэнэт хүний амь нас эрсдэж, нөхцөл байдал улам хүндэрч байгаад дүгнэлт хийж, өөрийн компанийн цэвэр ашгаас 2 чиглэлийн 2 урсгалтай хатуу хучилттай автозам барих ажлыг хэзээ эхлүүлж, ашиглалтад өгөх талаар:**

Энэхүү авто замын төслийг концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах- шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан.

Төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг Концессын тухай хуулийн дагуу урьдчилсан болон уралдаант гэсэн 2 үе шаттайгаар 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд зарласан. Уралдаант шалгаруулалтад 2 түншлэл төслийн санап ирүүлсэн. Саналыг 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авч, комисс үнэлгээ хийн, хамгийн сайн санал ирүүлсэн байгууллагатай гэрээний хэлцэл хийж, Засгийн газарт танилцуулсны дагуу тус түншлэлийн төсөл хэрэгжүүлэхээр байгуулсан компанитай болох "Тал нутгийн хөгжлийн зам" ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг Засгийн газрын 2018 оны 10 сарын 31-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор Үндэсний хөгжлийн газарт олгосны дагуу "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" концессын гэрээг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан.

Концесс эзэмшигч нь 6 сарын хугацаанд гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүдийг хангаснаар концессын гэрээ хүчин төгөлдөр болно.

Концессын гэрээнд: Төслийн нийт хөрөнгө оруулалт 412 633 000 ам доллартай тэнцэх төгрөгөөс илүүгүй, Концессын гэрээний хугацаа 14.5 жил, Авто замыг барьж дуусгах хугацаа концессын гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2.5 жил, Концесс эзэмшигчийн концессын зүйлийг ашиглах хугацаа 12 жил байхаар,

Шинээр баригдах Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замыг зөвхөн Гашуунсухайт чиглэлд ачаа ачсан тээврийн

хэрэгсэл зорчихоор, харин одоогийн ашиглаж байгаа Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай авто замыг ачаагүй тээврийн хэрэгсэл зорчих буцах авто зам байхаар, Шинээр баригдах Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замд зорчих тээврийн хэрэгслийн 1 тонн ачаанаас авах хураамжийн хэмжээ 3.4 ам доллартай тэнцэх төгрөгөөс илүүгүй байхаар, Буцах Ухаахудаг- Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай авто замын төлбөр түүний нөхцөлийг концессын гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш концесс эзэмшигч нь "Эрдэнэс монгол ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан харилцан тохиролцсон байхаар тусгасан байна.

**4.2.Орон нутгийн Тавантолгойн ажилчдын хотхон нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн лицензтэй талбай дээр байгаатай холбогдуулан нүүлгэн шилжүүлэх, шинээр төвлөрсөн суурин газрыг байгуулах талаар/одоогийн Цогтцэций сумын төвийг нүүлгэн шилжүүлэх, шинэ суурьшмал бүсийг байгуулах зэргээр/**

Хот төлөвлөлтийн төсөл буюу Шинэ суурьшлийн бүс "Таван толгой" хот нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Таван толгойн бүлэг ордыг түшиглэн тухайн бүс нутагт хийгдэх томоохон бүтээн байгуулалт болох юм. Уг төслийг хэрэгжүүлснээр цагаан овоо багийг нүүлгэн шилжүүлэх, цаашид олборлолтоо хэвийн явуулах, компанийг нийгэмд эергээр таниулах, ажилтан албан хаагчдын амьдралын баталгаа, ажлын бүтээмж, уялдаа холбоог сайжруулахаас гадна, тухайн бүс нутагт ажиллаж байгаа иргэдийн амжиргааг дээшлүүлэх, хотын төвлөрлийг бууруулах тухайн сум орон нутгийн хөгжил цэцэглэлтэд бодит үнэтэй хувь нэмэр оруулах юм. Энэ ажлын хүрээнд орон нутгийн удирдлага, "Тавантолгой" ХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК болон, эрдэмтдийн зөвлөлөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, төсөл хэрэгжүүлэх байршилыг судлан тогтоосон. Төсөлд шаардагдах нийт төсвийг нарийвчлан гаргахаар судалгааны ажлыг гүйцэтгэтгэж байна.

**4.3.2019 оны улсын төсөвт нүүрсний экспортыг 42,0 сая тонн болгон нэмэгдүүлсэн бөгөөд үүний 40 орчим хувийг төрийн 100 хувийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн борлуулалт бүрдүүлэх бөгөөд Гашуун сухайт хүртэлх авто зам, Цагаан хадны өнөөгийн дүр төрх/жолооч нар олон хоногоор машиндаа хонодог гэх мэт/, Цогтцэций сумын иргэдийн амьдрах нөхцөл байдал гээд тухайн компани нь Нийгмийн хариуцлагын хүрээнд хийх олон ажлыг шат дараалан хийж хэрэгжүүлэхгүйгээс болж нөхцөл байдал хүндэрч байгаа талаар:**

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д "тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" гэж заасныг үндэслэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК Өмнөговь аймагтай хамтын ажиллагааны гэрээг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр 2018 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Даланзадгад хотноо гарын үсэг зурсан. Гэрээний хүрээнд компани орон нутагтай дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон:

1. орон нутагт иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх;
2. орон нутгийн хөгжлийг дэмжих;
3. байгаль орчныг хамгаалах;



4. нөлөөллийн бүс дэх иргэд болон сумын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;
5. түүх соёлын дурсгалт зүйлс, нутгийн иргэдийн өвөлжөө, хаваржааг хамгаалах;
6. үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
7. Дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг болно.

Компани нь 2018 оны төсвийн хүрээнд Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахаар нийт 179,400,568 төгрөг зарцуулсан бөгөөд энэ хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

а/ Цогтцэций суманд 2 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын хүрээнд уг цэцэрлэгийг хашаажуулсан. 2018 оны намрын “Бүх нийтээр мод тарих” өдрийг тохиолдуулан 700 ширхэг суулгац тариалсан.

б/ Сумын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор “Энэрэхүй-Ухаан” ӨЭМТ-д 8.989.900 санхүүжилт олгож чийрэгжүүлэлтийн өрөөг бүрэн тохижуулж 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад оруулж хүлээлгэн өгсөн.

в/ Өмнөговь аймгийн ахмадуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, амралт сувилалд хамруулах ажилд дэмжлэг үзүүлсэн.

г/ Нөлөөллийн бүс дэх иргэдийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажилд дэмжлэг үзүүлсэн бөгөөд энэ хүрээнд 10 мэс заслын ажилбар хийгдэн, нийт 1,147 хүн хамрагдсан.

д/ Гэрээний 4.7.2 заалтад тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр Цогтцэций сумын Цагаан Овоо багийн иргэдийн газар болон эд хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн тодорхой хэсгийг хариуцна гэж заасны дагуу компанийн зүгээс Цагаан овоо багийн иргэдийн газар болон эд хөрөнгийн үнэлгээг хийлгэх компанийг сонгон шалгаруулж үнэлгээг хийх ажиллагаа явагдаж байна.

е/ Орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэгчдээс 111,732,541 төгрөгийн худалдан авалт хийж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин ажилласан.

ё/ Ерөнхий боловсролын сургуулийн болон, сургуулийн өмнөх боловсролын нийт 127 багшийг Багшийн хөгжил-чанартай сургалт сэдвийн хүрээнд чадавхижуулах сургалтад хамруулсан.

ж/ Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон тус аймгийн Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст тус бүр Уаз-Фургон маркын автомашин өгөхөөр хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалт зарласан. Үүний үр дүнд Уаз-Фургон маркын автомашиныг Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Нутгийн Удирдлагын Ордонд 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдөр хүлээлгэн өгсөн.

з/ Тоосжилтыг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд Цогтцэций сумын Сийрст багийн нүүрс тээвэрлэлтийн 8.2 км шороон замыг хатуу хучилттай авто зам болгож 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

и/ “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхайгаас Цогтцэций сумын төвтэй холбох 16 км хатуу хучилттай авто замыг барьж байгуулахаар орон нутагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгасан бөгөөд зураг төслийн ажил хийгдээд байна.

й/ Даланзадгад хотод 1200 хүүхдийн хүчин чадал бүхий ерөнхий боловсролын сургуулийн цогцолбор барилгыг шинээр барьж байгуулах ажлын зураг төсөл хийсэн.

к/ “Ногоон говь” хөтөлбөрийн хүрээнд 10 га талбайд мод үржүүлгийн талбай байгуулахаар төлөвлөсний дагуу 2018 онд Цогтцэций сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдснаар хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

л/ Тээврийн жолооч нарын хариуцлагыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослыг бууруулах, стандартын дагуу тээвэрлэлт гүйцэтгэж хэвшүүлэх зорилгоор тээврийн жолооч нарын дунд “Саятан жолооч” уралдаант шалгаруулалтыг зохион байгуулсан.

м/ Бүтээн байгуулалтаас бусад нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудад нийт 291,133,109 төгрөг зарцуулаад байна.

**4.4.Улсын Их Хурлын тогтоолоор IPO гаргаж, уг хөрөнгөөр нүүрс угаах зэрэг үйлдвэрүүд барьж байгуулж говийн гүний усыг ашиглахаар танилцуулсан бөгөөд энэ оноос эхлэн урьдчилан төсөвт тусган гол мөрний усны урсацыг эргүүлэн ус татах ажлын ТЭЗҮ хийх, гүний усыг ашиглахгүй байх талаар хийж хэрэгжүүлсэн ажил, жилийн хугацаанд ямар бодлого баримталж байгаа талаар:**

Өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд гүний болон гадаргын уснаас Тавантолгой нүүрсний ордын усны хэрэгцээг хангахаар төлөвлөж ажиллаж байна.

Усан хангамжтай холбоотой Өмнөговь аймагт орших Балгасын улаан нуурын усыг ашиглах тогтоол, шийдвэрийг холбогдох газруудаас авч ТЭЗҮ-ийг 2012 онд боловсруулсан боловч Өмнөговь аймгийн ИТХ-ын 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 68 дугаар албан бичгээр орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.

Өнөөгийн байдлаар компани Тавантолгой нүүрсний ордын усны хэрэгцээг Өмнөговь аймгийн Загийн усны хөндийгөөс хангахаар төлөвлөн техник эдийн засгийн үндэслэлийн ажил хийгдэж байна.

Цаашид компанийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалан татан төвлөрүүлсэн хөрөнгөөр эхний ээлжид дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэн зардал багасч, ашиг орлогоо боломжоороо бүрдүүлснээр томоохон усны төслүүд болох Хэрлэн говь, Орхон гол болон Саарал ус ашиглах зэрэг усан хангамжийн төслүүдийг шат дараалалтай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү томоохон усан хангамжийн төслийн асуудлыг БОАЖЯ-ны сайдаар ахлуулсан ажлын хэсэг санхүүжилт, тооцоо судалгааны ажлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

**4.5.Өмнийн говьд үлдэх өгөөжийг төлөвлөж, ирээдүй хэтийн бодлогыг зөвөөр тодорхойлох зайлшгүй шаардлага үүссээр байна. Үүнд: Даланзадгад, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдад шинээр хот төлөвлөлтийг хийх, хүн амын төвлөрлийг бий болгох, дэд бүтэц /хилийн боомтууд, олон улсын нисэх онгоцны буудал, төмөр зам, цахилгаан эрчим хүч/, тээвэр ложистик, аж үйлдвэрийн цогцолборыг байгуулах, улмаар уул, уурхайн орлогод тулгуурлан эдийн засгийн олон талт бодлогыг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарыг хослуулан хөгжүүлэхэд төрөөс баримталж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар:**

Гашуунсухайтын боомтын нүүрс тээвэрлэлтэд үүсээд байгаа хүндрэл бэрхшээлийг судалж хилээр нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, байгаль орчинд

үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл болон авто замын ачаалал, осол зөрчлийг бууруулах, тээвэрлэгч жолооч нарын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Авто зогсоолын цоцолбор” төслийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2018 оны 101 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолын дагуу авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламжийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр Гашуунсухайт боомт болон Цогтцэций суманд 2019 оны II улиралд тус тус ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх, 40 ангиллын хүчин чадалтай олон улсын нөөц нисэх буудал болгохоор зураг төсөл боловсруулах ажлыг хийгдэж байна.

Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсаны хүрээнд Өмнөговь аймагт 15-20 сая тн хүчин чадалтай ачаа хүлээн авах, шилжүүлэн ачих терминалыг 2021 онд барихаар төлөвлөөд байна.

Тавантолгой- Барууннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто зам: Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх авто замын төслийг концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 277 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Концесс олгох уралдаант шалгаруулалтыг Концессын тухай хууль, Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор баталсан “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-ын дагуу урьдчилсан болон уралдаант гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болон Үндэсний хөгжлийн газрын цахим хуудсанд зарласан. Оролцогчдын саналыг 2018 оны 05 сарын 02-ны өдөр хүлээн авч, үнэлгээ хийсэн. Засгийн газрын 2018 оны “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 330 дугаар тогтоолын дагуу тус төслийн концессын гэрээг 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан.

Концессын хугацаа 22 жил 6 сар, концесс эзэмшигч нь өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр төслийг бүрэн санхүүжүүлэхээр гэрээ байгуулагдсан. Гэрээнд заасны дагуу 6 сарын дотор концесс эзэмшигч нь гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүдийг ханган эрх бүхий этгээдэд хүргүүлэх бөгөөд эрх бүхий этгээд нөхцөл хангагдсан гэж үзвэл гэрээ хүчин төгөлдөр болсныг баталгаажуулах бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор авто замыг ашиглалтад оруулна. Авто зам ашигласны төлбөр тонн тутамд 0.8 центээс ихгүй байна./НӨАТ-гүй/

Концесс эзэмшигчийн зүгээс авто замын ТЭЗҮ-ийг боловсруулан, авто замын салбарын Шинжлэх, ухаан техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмжийн хамт тус яаманд хандсаны дагуу холбогдох хууль, журмын дагуу авто замын чиглэл батлах тухай сайдын тушаалын төсөл боловсруулан, газруудаас санал авч байна.

Тавантолгой-Оюутолгой-Ханги чиглэлийн тусгай зориулалтын авто зам: Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн авто зам төслийг зураг концессын “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан.

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 45 дугаар тэмдэглэлээр Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн хатуу хучилттай авто зам төслийн авто замын чиглэлийг Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолд зааснаар Тавантолгой-Оюутолгой-Ханги чиглэл болгон өөрчилж, концессын гэрээний хэлэлцээ хийж, санал дүгнэлтээ Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасан.

Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын хүрээнд Тавантолгойн ордыг түшиглэн холбогдох дэд бүтцийг барьж байгуулах ажлуудыг үе шаттай авч хэрэгжүүлэх юм.

-----oOo-----